



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

□ Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгах тухай □

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1, 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 5.5 дугаар зүйлийн 10, 8.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.32 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Пример дилер ХААБ” ХХК-ийн хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 2028 оны 02 дугаар сарын 28-ны өдрийг хүртэл сунгасугай.

2.Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгасантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг “Хөдөө аж ахуйн бирж” ХХК (О.Нарандэлгэр), “Пример дилер ХААБ” ХХК (Л.Зоригтбаатар)-д тус тус үүрэг болгосугай:

1/харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх;

2/Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журамд заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлэх;

3/энэхүү тогтоолтой нийцүүлэн холбогдох дүрэм, журам, биржийн арилжааны системд зохих өөрчлөлтийг оруулж, зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны дансанд сар бүрийн эцэст тогтмол төвлөрүүлж ажиллах.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН